АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн хүний эрх, эрх чөлөө, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаа.

Энэхүү өөрчлөлтөөр нам, эвслээс орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвшүүлэх нийт нэр дэвшигчийн 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байхаар тогтоохын зэрэгцээ нэр дэвшигчдийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах, гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрог тус бүрд нэр дэвшигчдийн 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байхаар зохицуулж байна. Мөн эдгээр шаардлагыг хангаагүй тохиолдолд нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах эрх зүйн үндэслэлийг тусгалаа.

Ингэснээр орон нутгийн сонгуулийн нэр дэвшигчийн хүйсийн квот нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Улс төрийн намын тухай хуульд тогтоосон 40 хувийн төлөөллийн шаардлага болон Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2028 оны ээлжит сонгуулиас хэрэгжүүлэхээр тогтоосон 40 хувийн зохицуулалттай уялдахын зэрэгцээ хүйсийн тэгш төлөөллийг зөвхөн нэр дэвшигчдийн нийт тоогоор бус, жагсаалтын дараалал болон тойрог тус бүрд хангах нөхцөл бүрдэнэ.

Хуулийн төслийг 2028 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар шинээр төрийн байгууллага байгуулах, орон тоо нэмэгдүүлэх, улсын болон орон нутгийн төсөвт тогтмол нэмэлт зардал бий болгох зохицуулалт тусгагдаагүй болно.

---o0o---